

## ТӨР-ИРГЭНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ

/Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга/

Дорнод аймаг

2026.02.09

№	Хуулийн төсөл /зүйл, заалт/	Санал	Үндэслэл	Тайлбар
1.	5.1.7. Хяналт шалгалтыг давхардуулахгүй зохион байгуулах	Хяналт шалгалтыг улирал тутам давхардуулахгүй зохион байгуулах		Чиг үүргийн хяналтыг давхардуулахгүй байх
2.	Хуулийн 5.1.9. хяналт шалгалтад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж, хяналт шалгалтын бүртгэлийг цахим хэлбэрээр нэгтгэн бүртгэх, удирдах	Эрсдэлийн үнэлгээг байгууллага, аж ахуйн нэгжүүд жил бүр цахимаар өөрийгөө үнэлж, тайлангаа илгээдэг байх.	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоол  Боловсролын сайдын 2025 оны А/37 дугаар тушаалтай уялдуулах	Хэрэв өөрийгөө "бага эрсдэлтэй" гэж үнэлсэн бөгөөд тэр нь үнэн бол төлөвлөгөөт шалгалтаас чөлөөлөх урамшуулал олгох -Салбарын бодлого, чиглэлийг уялдуулах
3.	11.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төлөвлөгөөт хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 хоногоос илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүгнэлт гаргах хугацаа хамаарахгүй.	Ажлын 5-10 хоног буюу 2 долоо хоног	Шалгалтын дүгнэлт гаргах хугацаа тодорхой, шуурхай байх	Шалгуулагч байгуулагад хүлээлт үүсдэг, ажил удаашрах хандлагатай.
4.	12.3.Энэ зүйлийн 12.2-т заасан гомдол, өргөдөл, хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор судлан үзэж, шалгалтыг эхлүүлэх, эсхүл зөрчлийн шинжтэй бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.	Төлөвлөгөөт шалгалтын үр дүн болон зөрчлийг мэдээлэх арга замыг тодорхой болгох	Жишээ нь барилгын салбарт "Улсын комисс хүлээж авсан" гээд ашиглалтад оруулчихдаг. Ашиглалтад оруулсны дараа чанаргүй баригдсанаас үүдээд зөндөө асуудал гардаг. Үүнийг хэрхэн шийдвэрлэх талаар тусгах	
5.	11.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төлөвлөгөөт хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 хоногоос илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүгнэлт гаргах хугацаа хамаарахгүй.		шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 хоногоос илүүгүй байх бөгөөд шалгалтын дүгнэлт гаргах хугацааг оруулан тооцно	Хан-Уул сургууль
6.	14.3. Дараах чиглэлийн хяналт шалгалтыг мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно: 14.3.1-д боловсролын хяналт	Боловсролын хяналт шалгалтыг Засгийн газрын Хяналтын ерөнхий газар, эсвэл салбарын хяналт хийж гүйцэтгэнэ.-гэж өөрчлөх саналтай.	Алсын хараа-2025 Хоёр. Хүний хөгжил Зорилго-2 II үе шат (2031-2040): 4.Боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой	Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх бөгөөд мэргэшлийн байх; гэдэг зарчим алдагдаж, багшлах боловсон хүчин

		Боловсролын хяналтын чиглэлээр хийгдэх хяналтыг мэргэшсэн мэргэжлийн хүн буюу боловсролын хяналтын улсын байцаагчаар хэрэгжүүлэх нь зөв.	болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байна. Боловсролын ерөнхий хуулийн 35.1.Боловсролын хяналт шалгалтыг холбогдох хуульд заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.	хомсдож, эцэг эх, иргэдийн харилцаа хандлагад шантарч байгаа энэ үед тохиромжгүй юм.
7.	24.3.1.“эрсдэл бага” гэж дүгнэсэн бол зөвлөмж хүргүүлэх;	“эрсдэл бага” гэж дүгнэгдсэн, үнэлгээ үнэн зөв бол тус байгууллагыг урамшуулах		Ажлын гүйцэтгэл, урамшууллын тогтолцоотой уялдуулах

### НЭГТГЭСЭН:

### БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Р.ОЮУНТУЯА

*Дорнод аймгийн Боловсролын газар*

*Захиргаа, удирдлагын хэлтэс, 304 тоот*

*Боловсролын хяналтын улсын байцаагч Р.Оюунтуяа*

*Емэйл: [oyuuntuyaa68is@moes.edu.mn](mailto:oyuuntuyaa68is@moes.edu.mn) Утас: 99588111*